

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 03 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2025 оны 04 дүгээр сарын 07

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 03 дугаар сарын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын 36 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийт арга хэмжээний 61.1 хувь нь үр дүнтэй буюу 100 хувь, 22.2 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 90-70 хувь, 16.6 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 50-30 хувьтай үнэлэгдлээ. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Дундаж хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	
1	2	3	4	5	6	7	8
36	22	6	2	2	4	-	86.1

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан арга хэмжээнүүд бүгд үр дүнтэй буюу 100 хувийн биелэлттэй, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан 26 арга хэмжээнүүдийн дундаж үнэлгээ нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 88.07 хувийн биелэлттэй бол Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна” зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 3 арга хэмжээнүүдийн

дундаж нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 36.6 хувиар тус тус үнэлэгдсэн.
(Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	3	-	-	-	1	2	36.6
2	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	7	-	-	-	-	100
3	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	26	15	6	2	1	2	88.07
Нийт		36	22	6	2	2	4	74.9

Чиглэл тус бүрээр авч үзвэл Захиргаа, удирдлагын газар, Виз, зөвшөөрлийн газар, Санхүү, хангалт үйлчилгээний газар, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс төлөвлөсөн арга хэмжээнүүдийн үнэлгээ буурч үр дүнг нэмэгдүүлж, эрчимжүүлэх шаардлагатай бол бусад нэгжийн төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж 100 хувиар үнэлэгдсэн. Үнэлгээ буурсан арга хэмжээнд:

- Захиргаа, удирдлагын газар: тодорхой үр дүнд хүрсэн-2, зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан ч үр дүн гараагүй-1, бэлтгэл ажил хийгдэж буй-1, нийт 4 арга хэмжээ;

-Виз, зөвшөөрлийн газар: тухайн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж буй-1, нийт 1 арга хэмжээ;

-Санхүү, хангалт үйлчилгээний газар: тодорхой үр дүнд хүрсэн-1, нийт 1 арга хэмжээ;

-Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс: тавьсан зорилт арга хэмжээндээ бүрэн хүрээгүй боловч өөрсдөөс шалтгаалах арга хэмжээг авч ажилласан-1, нийт 1 арга хэмжээ;

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс: тодорхой үр дүнд хүрсэн -3, нийт 3 арга хэмжээ;

-Мэдээллийн технологийн хэлтэс: боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн-2, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатандаа байгаа-2, нийт 4 арга хэмжээ;

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Захиргаа, удирдлагын газар	15	11	2	1	-	1	92
2	Виз, зөвшөөрлийн газар	3	2	-	-	-	1	76.6
3	Иргэний харьяаллын газар	1	1	-	-	-	-	100
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	100
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	3	2	1	-	-	-	96.6
6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	2	1	-	1	-	-	85
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	2	-	2	-	-	-	90
8	Мэдээллийн технологийн хэлтэс	4	-	-	-	2	2	36.6
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	1	-	-	-	-	100
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	-	1	-	-	-	90
11	Санхүүгийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
Нийт		36	22	6	2	2	4	87.9

Мөн газар хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээ нь тодорхой үр дүн гарсан буюу 90 хувь, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээний биелэлт 100 хувь үнэлэгдсэн байна. Үүнд:

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2025 оны 03 дугаар сард төлөвлөн гүйцэтгэсэн 36 арга хэмжээний хэрэгжилт 86.1 хувьтай үнэлэгдлээ. Энэ нь өмнөх сарын үйл ажиллагааны үнэлгээнээс 7.1 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд үнэлгээ буурсан арга хэмжээнүүдийн үр дүн сайжраагүй тул цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90-70 хувьтай үнэлэгдсэн

Албан хаагчдын албан хэрэгцээнд архивын баримтыг ашиглалтад олгох (хэрэгжилт 90 хувь)

-Захиргаа, удирдлагын газар архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журмын дагуу алдаа, дутагдалгүй, бүрэн гүйцэтгэх;

Шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад хамруулах (хэрэгжилт 90 хувь)

-Тус арга хэмжээг төлөвлөлт, шалгуур үзүүлэлтийг бүрэн биелүүлж үр дүнг удирдлагад танилцуулах шаардлагатай.

Байгууллагын үйл ажиллагааны сарын тайлан нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх (хэрэгжилт 90 хувь)

-Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс “Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад баримтлах заавар”-ын дагуу хугацаанд нь гүйцэтгэж хэвших;

Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 02 дугаар сарын мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (хэрэгжилт 90 хувь)

-Холбогдох газар, нэгжүүд гадаадын иргэний бүртгэл, хяналтын мэдээгээ журмын дагуу хугацаанд гаргаж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст ирүүлж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс нь сар бүрийн мэдээг журамд заасан хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлэхэд анхаарч ажиллах;

Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдлийг боловсруулж, нийтлэх (хэрэгжилт 90 хувь)

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс нь нээлттэй өгөгдлийг алдаагүй, үнэн зөв боловсруулж, хугацаанд нь нийтэлж хэвших;

Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлтэд хяналт тавих (хэрэгжилт 90 хувь)

-Санхүү, хангалт, үйлчилгээний газар нь үр дүнг нэмэгдүүлж 2023, 2024 оны тооцоо нийлж, баталгаажуулж дуусгах;

Гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газартай хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд уулзалт зохион байгуулах (хэрэгжилт 70 хувь)

-Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс нь шалгуур үзүүлэлтийн дагуу, үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах;

Төрийн тусгай гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулах (хэрэгжилт 70 хувь)

-Захиргаа, удирдлагын газар нь шалгуур үзүүлэлтийн дагуу, үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах;

2. “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-50 хувьтай үнэлэгдсэн

Eimmigration.mn, ISM програмуудын хуучин датаг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” систем рүү хөрвүүлэх (хэрэгжилт 50 хувь)

-Тус арга хэмжээг төлөвлөлтийн дагуу бүрэн хийж гүйцэтгэх нийт 7,713,118 мөр өгөгдлийг бүрэн шилжүүлж дуусгах шаардлагатай;

Мэдээллийн аюулгүй байдлын газраас ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг хүргүүлэх (хэрэгжилт 50 хувь)

-Мэдээллийн технологийн хэлтэс нь тус арга хэмжээг төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлж, зохион байгуулах;

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийг сайжруулах (хэрэгжилт 30 хувь)

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” болон цахим визийн систем (evisa)-ийн мэдээллийн сан хооронд өгөгдөл солилцох холболтыг хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх (хэрэгжилт 30 хувь)

-Дээрх 2 арга хэмжээг Мэдээллийн технологийн хэлтэс нь шалгуур үзүүлэлтэд тусгагдсан үйлчилгээний хөгжүүлэлтүүдийг хийж дуусгах, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх;

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийг сурталчлан таниулах чиглэлээр видео контент бэлтгэх (хэрэгжилт 30 хувь)

- Виз, зөвшөөрлийн газар нь зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн хэрэгжүүлж, зохион байгуулах;

Чиглүүлэх болон чадавхжуулах сургалтын хөтөлбөр шинээр боловсруулж, батлуулах (хэрэгжилт 30 хувь)

-Захиргаа, удирдлагын газар нь зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн хэрэгжүүлж, зохион байгуулах;

-Арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтод чиглэсэн хэрэгжилт, үр дүнг сайжруулахаар Мэдээллийн технологийн хэлтэс нь удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай ч арга хэмжээ аваагүй, чанар, үр дүн сайжраагүй тул нэгжийн улирлын үнэлгээнд тооцож ажиллахыг санал болгож байна.

Мөн бусад газар, нэгжүүд төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түшиндээ нийцүүлэн, товч тодорхой, үнэн зөв тайлагнаж, хугацаанд нь хэрэгжүүлж, үр дүнг нэмэгдүүлж ажиллахыг зөвлөмж болгож байна.

3. “Үр дүнтэй” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 22 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.